



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ГЕГ-ын Замын-Үүд дэх Гаалийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2021/145/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Сайншанд сум

2021 он

Дарга, тэргүүлэх аудиторын үүргийг түр орлон гүйцэтгэгч:
Т.Ган-Өлзий

Утас: 7052-2734

Цахим хаяг: Gan-Ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 7052-3020 Цахим хаяг:

Oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Ч.Хэрлэнчимэг

Утас: 70523020 Цахим хаяг:

Kherlenchimegch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ГЕГ	Гаалийн ерөнхий газар

Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	14
3. Аудитын тайлан.....	15
3.1. Ерөнхий зүйл.....	15
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	15
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	15
3.4. Материаллаг байдал	16
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	16
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	14
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	18
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.9. Аудитын илрүүлэлт.....	18
Залруулсан алдаа.....	18
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	19
Аудитын зөвлөмж.....	
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	19
4. Менежментийн захидал	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	22

1.Хараат бус аудиторын дүгнэлт


**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

ЗАМЫН-ҮҮД ДЭХ ГААЛИЙН
ГАЗРЫН ДАРГА Д.ЗОРИГОО
ТАНАА

2021.02.10 № 1-6/39
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Замын-Үүд дэх Гаалийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Замын-Үүд дэх Гаалийн газрын 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д

заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>147,387,011.47</u>	<u>153,480,001.68</u>
33	АВЛАГА	2,256,712.36	-
335	Бусад авлага	2,256,712.36	-
3351	Байгууллагаас авах авлага	1,058,712.36	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,198,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	145,130,299.11	153,479,990.68
351	Түүхий эд материал	6,812,849.60	9,641,519.60
35110	Тусгай зориулалттай материал	6,812,849.60	9,641,519.60
35300	Бэлэн бүтээгдэхүүн	3,551,227.00	1,863,143.00
354	Хангамжийн материал	120,339,222.51	127,970,328.08
35410	Бичиг хэргийн материал	18,094,792.99	7,820,236.00
35420	Аж ахуйн материал	63,377,506.59	90,187,275.99
35430	Сэлбэг хэрэгсэл	1,291,702.00	814,000.00
35440	Түлш, шатах тослох материал	9,611,961.49	9,985,000.00
35450	Барилгын засварын материал	971,653.84	53,976.72
35470	Бусад хангамжийн материал	26,991,605.60	19,109,839.37
35600	Мал амьтад	14,427,000.00	14,005,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>28,868,099,892.34</u>	<u>26,870,461,938.36</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	28,868,099,892.34	26,870,461,938.36
392	Биет хөрөнгө	28,712,759,892.34	26,635,967,232.36
39201	Барилга, байгууламж, орон сууц	13,046,645,362.55	13,064,985,362.55
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,208,692,671.86)	(1,581,537,877.96)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	503,155,460.00	710,755,460.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(431,237,901.79)	(464,205,460.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	28,052,056,609.84	28,595,858,456.24
39206	Хуримтлагдсан элэгдэл	(11,355,636,624.39)	(13,804,940,332.80)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	406,439,131.30	429,538,491.30
39208	Хуримтлагдсан элэгдэл	(305,876,073.31)	(320,393,466.97)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	5,906,600.00	5,906,600.00
393	Биет бус хөрөнгө	155,340,000.00	234,494,706.00
39301	Програм хангамж	5,600,000.00	84,754,706.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(5,600,000.00)	(5,600,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	155,340,000.00	155,340,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>29,015,486,903.81</u>	<u>27,023,941,940.04</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	36,000.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	36,000.00	-
413	Өглөг	36,000.00	-
4136	Бусад өглөг	36,000.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	36,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>29,015,450,903.81</u>	<u>27,023,941,929.04</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	29,015,450,903.81	27,023,941,929.04

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	12,677,926,754.55	12,677,926,754.55
51101	Өмч: - төрийн	12,677,926,754.55	12,677,926,754.55
512	Хуримтлагдсан үр дүн	15,574,350,323.46	13,582,841,348.69
51210	Өмнөх үеийн үр дүн	15,574,350,323.46	15,574,350,323.46
51220	Тайлант үеийн үр дүн	-	(1,991,508,974.77)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	763,173,825.80	763,173,825.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>29,015,486,903.81</u>	<u>27,023,941,940.04</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,908,143,546.48	5,537,515,185.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,959,656,546.48	1,050,498,945.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,959,656,546.48	1,050,498,945.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,926,048,107.68	1,037,235,825.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,926,048,107.68	1,037,235,825.00
120005	Түрээсийн орлого	27,516,000.00	
120009	Бусад орлого	6,092,438.80	13,263,120.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,948,487,000.00	4,487,016,240.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,944,631,500.00	4,464,180,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,944,631,500.00	4,464,180,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,855,500.00	22,835,640.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	11,100,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,855,500.00	11,735,640.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	8,727,308,750.36	7,529,024,159.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,727,308,750.36	7,529,024,159.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,722,412,472.61	7,354,177,849.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,981,464,731.51	3,342,247,299.12
210101	Үндсэн цалин	2,646,244,204.51	2,902,513,299.02
210103	Унаа хоолны хөнгөлөлт	72,818,500.00	80,934,000.00
210104	Урамшуулал	262,402,027.00	358,800,000.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	372,213,395.56	416,094,609.26
210201	Тэтгэврийн даатгал	238,851,265.53	267,217,524.50
210202	Тэтгэмжийн даатгал	45,197,173.97	50,078,352.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	23,798,886.53	26,654,695.69
210204	Ажилгүйдлийн даатгал	5,851,458.40	6,558,548.70
210205	Эрүүл мэндийн даатгал	58,514,611.13	65,585,488.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	429,213,692.97	341,155,120.82
210301	Гэрэл, цахилгаан	274,238,657.10	199,033,829.97
210302	Түлш, халаалт	113,090,012.27	100,294,385.85
210303	Цэвэр, бохир ус	41,885,023.60	41,826,905.00
2104	Хангамж, бараа материалын зардал	59,201,262.73	83,199,513.10
210401	Бичиг хэрэг	14,915,318.30	25,684,346.99
210402	Тээвэр, шатахуун	9,125,500.00	14,659,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,223,450.00	3,515,992.00
210404	Ном, хэвлэл	-	1,840,320.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,420,480.00	2,180,240.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,805,500.00	12,401,074.00
210408	Бараа материал акалсны зардал	26,711,014.43	22,918,340.11
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	95,641,324.57	61,850,612.14
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,786,034.90	17,358,158.02

ГЕГ-ын Замын-Үүд дэх Гаалийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	18,726,677.00
210604	Урсгал засвар	76,855,289.67	25,765,777.12
2107	Томилолт, зочны зардал	1,291,610.00	978,900.00
210702	Дотоод албан томилолт	1,291,610.00	978,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	78,054,370.16	57,984,765.70
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	59,556,360.00	36,038,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,999,760.00	4,000,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,400,090.00	442,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	187,000.00	187,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	705,579.00	6,337,020.00
210807	Газрын төлбөр	245,000.00	1,153,036.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	11,960,581.16	9,826,409.70
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,705,332,085.11	3,050,667,028.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,983,740.00	6,621,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	250,000.00	500,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	4,701,098,345.11	3,043,546,028.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,896,277.75	174,846,310.65
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	11,795,230.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	11,795,230.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,896,277.75	163,051,080.65
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,896,277.75	163,051,080.65
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(1,819,165,203.88)	(1,991,508,974.77)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	22,163,530,991.89	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	22,162,541,321.65	
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	989,670.24	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	22,163,530,991.89	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	23,982,696,195.77	(1,991,508,974.77)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,981,937,000.00	4,494,265,360.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	33,450,000.00	7,249,120.00
120	Нийтлэг татварын бус орлого	33,450,000.00	7,249,120.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	7,249,120.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	7,249,120.00
120005	Түрээсийн орлого	33,450,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,948,487,000.00	4,487,016,240.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,944,631,500.00	4,464,180,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,944,631,500.00	4,464,180,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,855,500.00	22,835,640.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	10,600,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,855,500.00	11,735,640.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,981,937,000.00	4,494,265,360.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,981,937,000.00	4,494,265,360.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,971,082,722.25	4,319,383,049.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,973,691,856.05	3,342,038,408.74
210101	Үндсэн цалин	1,834,490,156.05	1,866,255,526.41
210102	Нэмэгдэл	790,402,200.00	1,036,028,882.33
210103	Унаа хоолны хөнгөлөлт	83,099,500.00	80,954,000.00
210104	Урамшуулал	265,700,000.00	358,800,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	374,188,100.00	416,094,609.26
210201	Тэтгэврийн даатгал	279,494,500.00	299,693,909.26
210202	Тэтгэмжийн даатгал	22,673,400.00	29,100,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,138,700.00	23,280,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	8,534,700.00	5,820,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	45,346,800.00	58,200,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	422,801,660.70	342,548,337.35
210301	Гэрэл, цахилгаан	274,899,049.10	199,033,829.97
210302	Түлш, халаалт	106,017,588.00	101,687,602.38
210303	Цэвэр, бохир ус	41,885,023.60	41,826,905.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,483,900.00	40,223,458.00
210401	Бичиг хэрэг	8,799,100.00	8,875,900.00
210402	Тээвэр, шатахуун	6,866,000.00	12,849,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,094,200.00	3,515,992.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,555,700.00	1,392,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,168,900.00	13,589,866.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	91,055,463.50	98,070,430.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	33,798,682.00	25,977,490.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,400,000.00	40,868,340.00
210604	Урсгал засвар	51,856,781.50	31,224,600.00

ГЕГ-ын Замын-Үүд дэх Гаалийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2107	Томилолт, зочны зардал	1,291,610.00	978,900.00
210702	Дотоод албан томилолт	1,291,610.00	978,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	86,954,132.00	78,928,906.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	56,349,860.00	54,799,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,999,760.00	4,000,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,400,090.00	442,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	187,000.00	187,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,525,500.00	11,860,670.00
210807	Газрын төлбөр	245,000.00	1,153,036.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	16,246,922.00	6,485,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	616,000.00	500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	616,000.00	500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,854,277.75	174,882,310.65
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,855,500.00	11,795,230.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,855,500.00	11,795,230.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,958,000.00	36,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,958,000.00	36,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,040,777.75	163,051,080.65
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,040,777.75	163,051,080.65
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,677,926,754.55	763,173,825.80	39,557,046,519.23		52,998,147,099.58
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	12,677,926,754.55	763,173,825.80	39,557,046,519.23	-	52,998,147,099.58
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-		-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-		-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
C07	Тайлант үеийн үр дүн			(23,982,696,195.77)		(23,982,696,195.77)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,677,926,754.55	763,173,825.80	15,574,350,323.46	-	29,015,450,903.81
D01	2020 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,677,926,754.55	763,173,825.80	15,574,350,323.46	-	29,015,450,903.81
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	12,677,926,754.55	763,173,825.80	15,574,350,323.46	-	29,015,450,903.81
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-		-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
D08	Тайлант үеийн үр дүн			(1,991,508,974.77)		(1,991,508,974.77)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,677,926,754.55	763,173,825.80	13,582,841,348.69	-	27,023,941,929.04

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,464,180,600.00	4,308,378,639.35	155,801,960.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,464,180,600.00	4,308,378,639.35	155,801,960.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,464,180,600.00	4,308,342,639.35	155,837,960.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,388,818,700.00	3,342,038,408.74	46,780,291.26
210101	Үндсэн цалин	1,897,574,400.00	1,866,255,526.41	31,318,873.59
210102	Нэмэгдэл	1,049,344,800.00	1,036,028,882.33	13,315,917.67
210103	Унаа хоолны хөнгөлөлт	83,099,500.00	80,954,000.00	2,145,500.00
210104	Урамшуулал	358,800,000.00	358,800,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	455,702,500.00	416,094,609.26	39,607,890.74
210201	Тэтгэврийн даатгал	339,301,800.00	299,693,909.26	39,607,890.74
210202	Тэтгэмжийн даатгал	29,100,200.00	29,100,200.00	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	23,280,100.00	23,280,100.00	-
210204	Ажилгүйдлийн даатгал	5,820,000.00	5,820,000.00	-
210205	Эрүүл мэндийн даатгал	58,200,400.00	58,200,400.00	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	410,634,700.00	342,548,337.35	68,086,362.65
210301	Гэрэл, цахилгаан	238,880,000.00	199,033,829.97	39,846,170.03
210302	Түлш, халаалт	123,172,700.00	101,687,602.38	21,485,097.62
210303	Цэвэр, бохир ус	48,582,000.00	41,826,905.00	6,755,095.00
2104	Хангамж, бараа материалын зардал	40,582,600.00	40,223,458.00	359,142.00
210401	Бичиг хэрэг	8,875,900.00	8,875,900.00	-
210402	Тээвэр, шатахуун	12,849,900.00	12,849,200.00	700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,874,400.00	3,515,992.00	358,408.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,392,500.00	1,392,500.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,589,900.00	13,589,866.00	34.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	87,035,800.00	87,030,020.00	5,780.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	25,978,000.00	25,977,490.00	510.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	29,833,000.00	29,827,930.00	5,070.00
210604	Урсгал засвар	31,224,800.00	31,224,600.00	200.00
2107	Томилолт, зочны зардал	1,205,800.00	978,900.00	226,900.00
210702	Дотоод албан томилолт	1,205,800.00	978,900.00	226,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	79,539,700.00	78,928,906.00	610,794.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	54,800,000.00	54,799,400.00	600.00
210803	Даатгалын үйлчилгээ	4,053,000.00	4,000,200.00	52,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	967,700.00	442,700.00	525,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	187,000.00	187,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,891,100.00	11,860,670.00	30,430.00

ГЕГ-ын Замын-Үүд дэх Гаалийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210807	Газрын төлбөр	1,155,000.00	1,153,036.00	1,964.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	6,485,900.00	6,485,900.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	660,800.00	500,000.00	160,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	660,800.00	500,000.00	160,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	36,000.00	(36,000.00)
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	36,000.00	(36,000.00)
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		36,000.00	(36,000.00)
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,464,180,600.00	4,308,378,639.35	155,801,960.65
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,464,180,600.00	4,301,129,519.35	163,051,080.65
131001	Улсын төсвөөс санхүүжих	4,464,180,600.00	4,301,129,519.35	163,051,080.65
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	7,249,120.00	(7,249,120.00)
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	7,249,120.00	(7,249,120.00)

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	22,835,640.00	(22,835,640.00)
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	11,040,410.00	(11,040,410.00)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	11,040,410.00	(11,040,410.00)
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	11,040,410.00	(11,040,410.00)
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	11,040,410.00	(11,040,410.00)
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	11,795,230.00	(11,795,230.00)
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	11,795,230.00	(11,795,230.00)
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	22,835,640.00	(22,835,640.00)
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	22,835,640.00	(22,835,640.00)
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	10,600,000.00	(10,600,000.00)
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	500,000.00	(500,000.00)
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	11,735,640.00	(11,735,640.00)
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		-	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-	-

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

ГЕГ-ын Замын-Үүд дэх Гаалийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг ГЕГ-ын Замын-Үүд дэх Гаалийн газрын дарга Д.Зоригоо танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 26-ноос 2021 оны 01 дүгээр сарын 29-ны хооронд Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ч.Хэрлэнчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

ГЕГ-ын Замын-Үүд дэх Гаалийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/27 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

ГЕГ-ын Замын-Үүд дэх Гаалийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Гаалийн хууль, тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих,
- Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэл, түүний хөдөлгөөнд хяналт тавих.
- Татвар төлөгчөөс хураан авсан гаалийн болон бусад татварыг улсын төсөвт төвлөрүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомжид өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

ГЕГ-ын Замын-Үүд дэх Гаалийн газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

ГЕГ-ын Замын-Үүд дэх Гаалийн газрын 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

ГЕГ-ын Замын-Үүд дэх Гаалийн газрын 2020 оны шилэн дансанд дотоод аудит хийгдээгүй ба ГЕГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс тус байгууллагын шилэн дансны үйл ажиллагаанд өдөр тутмын хяналтыг тавьж ажилладаг байна.

ГЕГ-ын Замын-Үүд дэх Гаалийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны нийт батлагдсан төсөв болох 4,189,854.6 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 41,898.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон байна. Гүйцэтгэлийн үе шатанд сонгосон суурийг өөрчлөн нийт орлого болох 5,537,515.2 мянган төгрөгийн нэг хувиар тооцож, материаллаг байдлын түвшинг 55,375.2 мянган төгрөгөөр тогтоов.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Замын үүд дэх гаалийн газар 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,991,544.9 мянган төгрөгөөр буюу 6.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	2,256.7		-2,256.7
Урьдчилгаа			
Бараа материал	145,130.3	153,480.0	8,349.7
Үндсэн хөрөнгө	28,868,099.9	26,870,461.9	-1,997,638.0
Нийт хөрөнгө	29,015,486.9	27,023,941.9	1,991,545.0
Өр төлбөр	36.0		
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	29,015,450.9	27,023,941.9	1,991,545.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	29,015,486.9	27,023,941.9	1,991,545.0

Авлага данс үлдэгдэлгүй болж 2,256.7 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны авлагыг бүрэн барагдуулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 153,479.9 мянган төгрөг болж, 8,349.7 мянган төгрөгөөр өссөн нь Ковид-19 цар тахалтай холбоотойгоор албан хаагчдад шаардлагатай хамгаалах хэрэгсэл, ариутгалын бодис худалдан авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 26,870,461.9 мянган төгрөг болж, 1,997,638.0 мянган төгрөгөөр буурсан байгаа боловч, анхны өртгийн үнэлгээгээр 871,995.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь Гаалийн ерөнхий газраас 984,600.5 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авснаас шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь хөрөнгө оруулалтаар 30,500.0 мянган төгрөг, урсгал төсвийн худалдан авалтаар 34,061.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй шилжиж ирсэн 984,600.5 мянган төгрөгийн, нийт 1,049,161.5 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгөөс шилжүүлсэн хөрөнгө байхгүй ба 177,165.6 мянган төгрөгийн хөрөнгө акталж, анхны өртгийн үнэлгээгээр нийт 177,165.6 мянган төгрөгийн хөрөнгө хасагдсан байна.

Биет бус хөрөнгийн үлдэгдэл 79,154.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь ГЕГ-аас үнэ төлбөргүй шилжүүлэн өгсөн 5 төрлийн 65 ширхэг программ хангамжийг тус дансанд бүртгэсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр данс үлдэгдэлгүй болж, 36.0 мянган төгрөгөөр буурсан нь оны эхний үлдэгдэл болох өглөгийг барагдуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 27,023,941.9 мянган төгрөг болж 1,991,509.0 мянган төгрөгөөр буурсан нь 2020 онд 1,991,509.0 мянган төгрөгийн алдагдалтай ажилласнаас шалтгаалжээ. Учир нь үндсэн хөрөнгийн үлдэгдэл ихтэй учир тайлант хугацаанд 3,043,546.0 мянган төгрөгийн буюу үндсэн хөрөнгийн анхны өртгийн 7 хувьтай тэнцэх элэгдлийн зардлыг бүртгэсэн байна. Мөн төсвийн хөрөнгийн зарцуулагдаагүй үлдэгдэл болох 174,846.3 мянган төгрөгийг жилийн эцэст холбогдох дансанд төвлөрүүлж, үүнийг зардлаар бүртгэсэнтэй холбоотой байна.

2020 оны -ны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,370,628.4 мянган төгрөгөөр буюу 19.8 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үнэ төлбөргүй шилжүүлэн авсан хөрөнгө 1,888,812.4 мянган төгрөгөөр буурсан байна. Учир нь 2019 онд конторын өргөтгөлийн зориулалтаар 2,338,264.1 мянган төгрөгийг барилгыг ГЕГ-аас худалдан авч, байгууллагын дансанд үнэ төлбөргүй орлогоор бүртгэж байсан. Тайлант онд томоохон барилга байгууламжийг үнэ төлбөргүйгээр шилжүүлсэн аваагүй учраас буурсан үзүүлэлттэй байна.

Нийт зардал өмнөх оноос 1,198,284.6 мянган төгрөгөөр буюу 13.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал байгаа ба тайлант онд 1,657,552.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх оны үр дүн рүү хаасан болон нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 4,542,810.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 78,629.4 мянган төгрөгөөр бууруулж, 4,464,180.6 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь цалингийн зардлыг бууруулж баталсантай холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 4,464,180.6 мянган төгрөгийн төсөв баталж, үүнийг бүрэн улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,464,180.6 мянган төгрөгийн буюу санхүүжилтийг бүрэн авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 7,249.1 мянган төгрөг, нийт 4,471,429.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 4,308,378.6 мянган төгрөгийг зарцуулж, 163,051.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,308,378.6 мянган төгрөг буюу 96.5 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшил зардлыг 46,780.3 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардлыг 68,086.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь үндсэн үйл ажиллагааны арга хэмжээ 163,051.1 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна. Үүнд, цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал 46,780.3 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардал 39,607.9 мянган төгрөгөөр хэмнэгдсэн нь тайлант жилд орон тоо дутуу ажилласантай, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 68,086.4 мянган төгрөгөөр хэмнэгдсэн нь авто замын шалган нэвтрүүлэх боомтын барилгыг буулгасантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 10,600.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 500.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 11,735.6 мянга, нийт 22,835.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хандив тусламж болон дэмжлэгээр олгосон хөрөнгийг зориулалтын дагуу хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, дархлаа дэмжих бүтээгдэхүүн худалдан авахад 11,040.4 мянган төгрөгийг зарцуулж, туслах үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого болох 11,735.6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт санхүүжилтийн дансанд жил бүр давтагдах шинжтэй тогтмол орлого болох Соёмбо хотхоны халаалтын /Тус байгууллага нь уурын зуух ажиллуулж, нийтийн орон сууцыг халаадаг/ төлбөрийг төвлөрүүлсэн байна. Уг зөрчилд зөвлөмж өгөхөөр шийдвэрлэсэн.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 138 мэдээллээс 138 мэдээллийг хугацаандаа оруулсан байна. Хугацаа хугацаа хоцроосон болон цахим хуудсанд байршуулаагүй мэдээлэл байхгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 5,470.0 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хэрэгжүүлсэн тухай тайлбар ирүүлсэн. Аудитын явцад өмнөх онд өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад малын ашиг шимийг бүртгэлд тусгаж, зарцуулах зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 35,493.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, аудитын явцад 5,157.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 30,335.6 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж хүргүүлсэн.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Албан хаагчдаас суутгасан байрны төлбөрийг сар бүр авлага үүсгэж, орлогоор бүртгэх бичилтийг хийгээгүй байна. Суутган авч, байгууллагын дансанд шилжүүлэхдээ орлогоор хүлээн зөвшөөрч, авлагын дансанд бүртгэсэн байна. Нийт 5,157,5 мянган төгрөгийн төлбөрийг суутгаж, шилжүүлсэн байна. Албан хаагчдаас авах авлагыг зөвхөн мөнгөөр шилжин ирсэн дүнгээр бүртгэж байгаа нь авлагыг үнэн зөв бүртгэхгүй байх эрдлийг бий болгож байна. Тус алдааг аудитын явцад залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 30,335.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрч, зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгөв. Үүнд:

1. Үндсэн санхүүжилтийн дансанд тайлант онд 7,249.1 мянган төгрөгийн туслах үйл ажиллагааны орлогыг төвлөрүүлсэн байна. Үүнээс албан хаагчдаас суутгасан орон сууцны төлбөр жил бүр байгууллагын орлогоор бүртгэгддэг боловч тайлант онд орлогын төлөвлөгөөнд тусгаагүй байна. Тайлант онд нийт 5,157.5 мянган төгрөгийн орлогыг орон сууцны төлбөрөөс олсон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4-т *"Туслах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг төсвийн жилийн дундуур авсан бол түүнийг төсвийг нэмэлт төсөв хэлбэрээр, бусад тохиолдолд тухайн жилийн төсөвт тусган хэрэгжүүлнэ"*, 44.5.1-д *"Туслах үйл ажиллагааны үр дүнд бий болох ашгийг дараах зүйлд зарцуулна: ...тухайн байгууллагын үндсэн үйл ажиллагааны төсвийн санхүүжилтийг бууруулах"* гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Туслах үйл ажиллагаанаас олох орлогыг бодитоор тооцон, төсвийн эх үүсвэрт төлөвлөж, батлуулах тухай зөвлөмж өгөх.

2. Тайлант онд байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд жил бүр давтагдах шинжтэй, нийтийн орон сууцыг /Соёмбо хотхон/ дулаанаар хангасны төлбөр болох 11,735.6 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5.1-д *"Туслах үйл ажиллагааны үр дүнд бий болох ашгийг дараах зүйлд зарцуулна: ...тухайн байгууллагын үндсэн үйл ажиллагааны төсвийн санхүүжилтийг бууруулах"* Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалын 3.4.3-т *"...байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх явцад бий болдог жил бүр давтагдах шинжтэй тогтмол орлогыг төсөвт тусгахгүй орхигдуулахыг хориглоно"* гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Жил бүр давтагдах шинжтэй орлогыг үнэн зөв тооцож, төсвийн эх үүсвэрт төлөвлөж, батлуулах тухай зөвлөмж өгөх.

3. Тайлант онд 18,600.0 мянган төгрөгийн мөнгөн хандив, тусламжийг БНХАУ-ын Замын-Үүд дэх Консулын газар болон Лекс ойл ХХК-аас авсан байна. Хандивыг хүлээн авахдаа дээд шатны байгууллагаас зөвшөөрөл аваагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4-т *"Төсвийн байгууллага төсвийн **ерөнхийлөн захирагчаараа дамжуулан** ... төрийн болон орон нутгийн өмчит бус хуулийн этгээдээс мөнгөн хөрөнгө, хөдлөх эд хөрөнгийн хэлбэрээр тусламж, хандив авч болно"*, НАНБХАСЗАСЗУСТХ-ийн 17 дугаар зүйлийн 17.3-т *"Албан тушаалтан хандив, санхүүгийн туслалцааг авахын өмнө өөрийн удирдлага, эсхүл эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан байна"* гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөх.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар авч үзэх болон анхаарал татсан асуудал илрээгүй болно.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. *Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал.*
 - 1.1. Илрүүлэлт: Тайлант онд 18,600.0 мянган төгрөгийн мөнгөн хандив, тусламжийг БНХАУ-ын Замын-Үүд дэх Консулын газар болон Лекс ойл ХХК-аас авсан байна. Хандивыг хүлээн авахдаа дээд шатны байгууллагаас зөвшөөрөл аваагүй байна.
 - 1.2. Эрсдэл: Хандивлагч этгээдтэй ашиг сонирхлын зөрчил үүсэх, хандив, тусламжийг зориулалтын дагуу зарцуулахгүй байх.
 - 1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4-т “Төсвийн байгууллага төсвийн **ерөнхийлөн захирагчаараа дамжуулан ... төрийн болон орон нутгийн өмчит бус хуулийн этгээдээс мөнгөн хөрөнгө, хөдлөх эд хөрөнгийн хэлбэрээр тусламж, хандив авч болно**”, НАНБХАСЗАСЗУСТХ-ийн 17 дугаар зүйлийн 17.3-т “Албан тушаалтан хандив, санхүүгийн туслалцааг авахын өмнө өөрийн удирдлага, эсхүл эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан байна” гэж заасны дагуу ТЕЗ-аараа дамжуулан хандив, тусламжийг авч, эрх бүхий албан тушаалтны зөвшөөрлийг авч байх.
 - 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөрчлийг хүлээн зөвшөөрсөн.
2. *Орлогын данстай холбоотой асуудал*
 - 2.1. Илрүүлэлт: Тайлант онд байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд жил бүр давтагдах шинжтэй, нийтийн орон сууцыг /Соёмбо хотхон/ дулаанаар хангасны төлбөр болох 11,735.6 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.
 - 2.2. Эрсдэл: Улсын төсвөөс авах санхүүжилтийн хэмжээ нэмэгдэх, орлогыг бүрэн бүрдүүлэхгүй байх.
 - 2.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5.1-д “Туслах үйл ажиллагааны үр дүнд бий болох ашгийг дараах зүйлд зарцуулна: ...тухайн байгууллагын үндсэн үйл ажиллагааны төсвийн санхүүжилтийг бууруулах” Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалын 3.4.3-т “...байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх явцад бий болдог жил бүр давтагдах шинжтэй тогтмол орлогыг төсөвт тусгахгүй орхигдуулахыг хориглоно” гэж заасны дагуу жил бүр давтагдах шинжтэй орлогыг үнэн зөв тооцож, төсвийн эх үүсвэрт төлөвлөж, батлуулах.
 - 2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөрчлийг хүлээн зөвшөөрсөн.
3. *Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал*
 - 3.1. Илрүүлэлт: Үндсэн санхүүжилтийн дансанд тайлант онд 7,249.1 мянган төгрөгийн туслах үйл ажиллагааны орлогыг төвлөрүүлсэн байна. Үүнээс албан хаагчдаас суутгасан орон сууцны төлбөр жил бүр байгууллагын орлогоор бүртгэгддэг боловч тайлант онд орлогын төлөвлөгөөнд тусгаагүй байна. Тайлант онд нийт 5,157.5 мянган төгрөгийн орлогыг орон сууцны төлбөрөөс олсон байна.
 - 3.2. Эрсдэл: Улсын төсвөөс авах санхүүжилтийн хэмжээ нэмэгдэх, орлогыг бүрэн бүрдүүлэхгүй байх.

3.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4-т "Туслах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг төсвийн жилийн дундуур авсан бол түүний төсвийг нэмэлт төсөв хэлбэрээр, бусад тохиолдолд тухайн жилийн төсөвт тусган хэрэгжүүлнэ", 44.5.1-д "Туслах үйл ажиллагааны үр дүнд бий болох ашгийг дараах зүйлд зарцуулна: ...тухайн байгууллагын үндсэн үйл ажиллагааны төсвийн санхүүжилтийг бууруулах" гэж заасны дагуу туслах үйл ажиллагаанаас олох орлогыг бодитоор тооцон, төсвийн эх үүсвэрт төлөвлөж, батлуулах.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөрчлийг хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020	Аудитын нэр: ГЕГ-ын Замын-Үүд дэх Гаалийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: ДГА-2021/145/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Замын-Үүд дэх Гаалийн газар	Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Үндсэн санхүүжилтийн орлогыг төлөвлөөгүй.	-	Зөвлөмж өгөх	Дарга, ерөнхий нягтлан бодогч	Д.Зориггоо, Г.Удвалмя даг
2	Жил бүр давтагдах шинжтэй орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн	11,735.6	Зөвлөмж өгөх		
3	Дээд шатны албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр БНХАУ-ын Консулын газар, ААН-ээс хандив авч, зарцуулсан.	18,600.0	Зөвлөмж өгөх		
4	Албан хаагчдаас суутгасан байрны төлбөрийн бичилтийг НББ-д буруу хийсэн	5,157.5	Аудитын явцад залруулсан		
ДҮН		35,493.1			